



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Ерөнхий чиглэл батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.8 дахь заалт, Өрсөлдөөний тухай хуулийн 13.4 дэхь заалт, Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зөвшөөрлийн зөвлөлийн 2013 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсын нутаг дэвсгэр дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход баримтлах ерөнхий чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан ерөнхий чиглэлийг Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсын нутаг дэвсгэр дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэхэд баримталж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зөвшөөрлийн зөвлөлийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.


САЙД



Н.УДВАЛ

001383

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 31-ны өдрийн 267 дугаар
тушаалын хавсралт



Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход
баримтлах ерөнхий чиглэл

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү баримт бичгийг гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсын нутаг дэвсгэр дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэхэд баримтлана. Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээг үндэслэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс зохиомлоор хэрэгцээ бий болгохоос сэргийлэх, иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор зарим мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлд тодорхой хязгаарлалттайгаар олгоно.

Хоёр. Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулах байгууллагын хувьд тэргүүлэх ач холбогдол өгөх чиглэлүүд:

3.1 Засгийн газар хоорондын болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гэрээг хэрэгжүүлэгч эрүүл мэндийн байгууллагууд;

3.2 Улсын хэмжээний үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд;

3.3 Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлэхгүй байгаа төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд;

3.4 Анагаах ухааны боловсрол олгох болон эрдэм шинжилгээний байгууллагууд;

3.5 “Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолд заасан шаардлагыг хангаж байгаа байгууллагууд;

Гурав. Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тэргүүлэх ач холбогдол өгөх чиглэлүүд:

1. Хүүхэд судлал

1. Хүүхдийн зүрхний эмгэг судлал
2. Хүүхдийн хэрлэг үе, мөчний судлал
3. Хүүхдийн мэдрэлийн эмгэг судлал
4. Хүүхдийн хоол эмчилгээ судлал

5. Хүүхдийн мэдрэлийн мэс засал
6. Хүүхдийн сэтгэцийн эмгэг судлал
7. Хүүхдийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг судлал
8. Хүүхдийн хавдар судлал
9. Хүүхдийн согог засал судлал
10. Хүүхдийн нүд судлал
11. Охид, өсвөр үе судлал
12. Перинатологи судлал



2. Мэс засал судлал

13. Ерөнхий мэс засал
14. Мэдрэлийн мэс засал
15. Зүрхний мэс засал
16. Судасны мэс засал
17. Бөөрний мэс засал
18. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал
19. Хэвлийн хөндийн дурангийн мэс засал
20. Цээжний хөндийн дурангийн мэс засал
21. Эрүү нүүрний мэс засал
22. Үений мэс засал
23. Нөхөн сэргээх мэс засал

3. Гэмтэл судлал

24. Гэмтэл, согог засал
25. Гэмтлийн мэс засал
26. Түлэгдэл судлал

4. Хавдар судлал

27. Хавдар судлал
28. Хавдрын мэс засал судлал
29. Хавдрын хими, туяа эмчилгээ

5. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ

30. Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг
31. Амь тэнссэн үеийн анагаах судлал
32. Өвдөлт судлал

6. Нүд, чих хамар хоолойн эмгэг судлал

33. Нүдний ар сегментийн эмгэг судлал
34. Нүдний торлогийн эмгэг судлал

35. Дотор чих, тэнцвэрийн эмгэг судлал
36. Дунд, дотор чихний бичил мэс засал судлал

7. Дотрын эмгэг судлал

37. Хэрлэг, үе мөчний эмгэг судлал
38. Элэгний эмгэг судлал
39. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг судлал
40. Эмнэл зүйн хор судлал
41. Эмнэлзүйн харшил судлал
42. Эмнэл зүйн дархлал судлал
43. Цусны өвчин судлал
44. Гемодиализ судлал

8. Мэдрэл, сэтгэцийн эмгэг судлал

45. Мэдрэлийн удамшлын эмгэг судлал
46. Тархи нугасны сүнэрэлийн эмгэг судлал
47. Тархи нугасны миелингүйжих эмгэг судлал
48. Эмгэг сэтгэл судлал
49. Донтох эмгэг судлал
50. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлал
51. Өтлөлтийн сэтгэл судлал
52. Бэлгийн эмгэг судлал
53. Нийгмийн сэтгэцийн эмгэг судлал

9. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн өвчин судлал

54. Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн булчирхайн эмгэг судлал
55. Үргүйдэл судлал
56. Эвсэл үр шилжүүлэлт судлал
57. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал
58. Эрэгтэйчүүдийн эмгэг судлал

10. Халдварт өвчин судлал

59. ХДХВ/ДОХ судлал
60. Сүрьеэ өвчин судлал
61. Хачигт халдвар судлал

11. Нөхөн сэргээх

62. Хөдөлгөөн засал
63. Ахуй засал
64. Хэл яриа засал



10. Бусад

- 65. Өрхийн анагаах ухаан судлал
- 66. Настны эмгэг судлал
- 67. Хөнгөвчлөх эмчилгээ судлал

11.Сувилахуйн чиглэл

- 68. Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй
- 69. Уушигны үйл оношийн сувилахуй
- 70. Мэс заслын сувилахуй
- 71. Гэмтэл, согог заслын сувилахуй
- 72. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний сувилахуй
- 73. Хүүхдийн сувилахуй
- 74. Өндөр настны сувилахуй
- 75. Сэтгэц, донтох эмгэгийн сувилахуй



Дөрөв. Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хязгаарлалттай олгох буюу шинээр олгохгүй мэргэжлийн чиглэл:

- 4.1 Уламжлалт анагаах ухаан;

Тав. Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй байх мэргэжлийн чиглэлүүд:

- 5.1 Эх барих;
- 5.2 Эм барих;
- 5.3 Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөр баталгаажаагүй эмчилгээ, оношлогооны технологи;